

Социалист орнуудад хувийн болгох нэр томъёог хэрэглэж заншаагүй байна. Гэлээ ч гэсэн эдийн засгийн энэ үзэгдэл Азийн социалист орнуудын заримд нь нэвтэрч, БНХАУ-д нэлээд ахиц олж, Вьетнам, Лаост үүсэх хандлагатай байна. Манай улсад хөдөө аж ахуйн гэрээ түрээсний зарим элементийг эс тооцвол хувийн болох явдал огт эхлээгүй гэхэд хилсдэхгүй. БНАСАУ-д байдал манайхтай төстэй юм.

Цаашдаа манай улс төлөвлөгөөт, зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэе, эдийн засгийн нээлттэй бодлого явуулъя, захиран тушаах системийн эдийн засгийн бүтцийг задлая гэвэл манайд хувийн болгох явцыг эхлээд зогсохгүй, түргэтгэх хэрэгтэй юм. Хувийн болгох үйл явцыг хөдөө аж ахуй хөгжүүлэх, үйлчилгээний хүрээг өргөтгөх, өргөн хэрэглээний зах зээлийн эрэлт, хэрэгцээг тогтворжуулах, алдагдалтай үйлдвэр, аж ахуйн газрыг багасгахад ашиглах явдал ирээдүйтэй бөгөөд үр ашигтай байх нь гарцаагүй.

\* Asia-Pacific report. 1987—1988. p. 72—84.

<sup>1</sup> Цаг үе. , 1989, No 34

<sup>2</sup> О. Богомолов. Социализм 90-ээд он. Залуучуудын үнэн. 1989 оны 10-р сарын 22., No 117

<sup>3</sup> МАХН-ын Төв Хорооны VII бүгд хурал. УБ., 1989, 59 дэх тал

## **ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦГОЙ БҮС-ХАЙНАНЬ**

**Борлууд С. Жаргалсайхан**

БНХАУ-д өөрчлөлт шинэчлэлтийг хэрэгжүүлж эхэлсэн цагаас хойш өмнөд хятадын тэнгист орших Хайнань арал хятадын удирдлага, эрдэмтэн, мэргэжилтнүүдийн анхаарлыг зүй ёсоор татах болсон юм. Юун хэмээвээс, энэхүү арал нь Тайвань, Гонконг, Макао болон зүүн өмнөд Азийн орнуудтай харилцахад ойр дөт, байгалийн ашигт малтмалаар арвин, байгаль, цаг уурын аятай таатай нөхцөлтэй болой. Иймд тус арлыг цаашид хөгжүүлэхэд бололцоотойгоос гадна энэ бүхэн нь хятадын улс төр, эдийн засгийн стратегид зүй ёсоор нийцэж байгаа юм.

Хайнань арлыг гадаадад нээх үйл явц гурван үе шаттайгаар хэрэгжиж байна.

1. 1981 оны 11-р сард Гуандун мужийн засаг захиргаа Хайнань аралд хөрөнгө оруулах, гадаадын худалдаачдад илүү уян хатан хандах шийдвэр гаргасан. Энэхүү арга хэмжээний үр дүнд 1981 онд тус арлын аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 697 сая 400 мянган юань, хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүн 1 тэрбум 363 сая юань, гадаад худалдаа 45,7 сая доллар, бодитой ашигласан гадаадын хөрөнгө 1 сая доллар байсан бол 1983 онд дээрх үзүүлэлтүүд тус бүр 860 сая 200 мянган юань, 1 тэрбум 876 сая юань, 15 сая 700 мянган доллар, 4 сая 300 мянган доллар болсон байна.<sup>1</sup> Энэ хугацаанд арлын эдийн засаг

алгуур удаан боловч тогтвортой хөгжиж байлаа. Харин гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалт тогтвортой бус байв.

2. Дэн Сяопин Гуандун, Фузян болон бусад мужаар явж ирээд 1984 оны 2-р сарын 24-нд ХКН-ын Төв Хорооны удирдах ажилтнуудтай уулзахдаа «...Бид Хайнань арлыг эзэмших хэрэгтэй байна. Хэрвээ Хайнаний эдийн засгийг хөгжүүлбэл бид асар их амжилт олох болно»<sup>2</sup> гэж хэлсний дагуу 1984 оны 4-р сард тус арлыг далайн эргийн 14 хотын хамт нээлттэй болгосон юм. Ийнхүү гадаад орнууд лугаа харилцах эрх хэмжээ, хүрээг нь өргөтгөснөөр арлын гадаад худалдаа эрс дээшлэв. 1984 онд арлын гадаад худалдаа 41 сая 100 мянган доллар, бодитойгоор ашигласан гадаад хөрөнгө 17 сая 800 мянган доллар байсан бол 1988 онд тус бүр 770 сая доллар, 114 сая 200 мянган доллар болтлоо өссөн. Энэ хугацаанд аж үйлдвэрийн болон хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл тогтвортой өсч ирсэн болно.

3. Дараахи нэг гол арга хэмжээ бол БХАТИХ-ын долоо дахь удаагийн сонгуулийн 1988 оны дөрөвдүгээр сарын 13-ны өдрийн анхдугаар чуулганаар тус арлыг Гуандун мужийн харьяалалаас гаргаж, бие даасан муж, эдийн засгийн онцгой бүс (ЭЗОБ) болгосон шийдвэр гаргасан юм.<sup>3</sup> Ийнхүү Хайнань арал нь одоогийн байдлаар хятадын хамгийн том эдийн засгийн онцгой бүс болсон билээ.

Хайнань нь олон жилийн турш хаагдмал байсан учир аж үйлдвэр хөгжсөнгүй харин хөдөө аж ахуй бага сага хөгжсөн болно. Хайнаний оршин суугчдын аравны найм нь хөдөө аж ахуйд ажилладаг агаад зөвхөн газар тариалангийн салбар гэхэд л аж үйлдвэр, хөдөө аж ахуйн нийт үйлдвэрлэлийн 60%, түүний экспортын 70% -ийг гаргадаг юм. Мужийн байгаль, цаг уурын онцлог байдал, ашигт малтмалын нөөц, уламжлалт аж ахуй, хөгжүүлж болохуйц аж үйлдвэрийн салбар зэрэгт олон талын судалгаа хийсний үндсэн дээр Хайнань мужийн хөгжлийн загварыг хятадын эрдэмтэд нэгэнт тодорхойлоод байна. Хятадын нэрт эрдэмтэн Хуан Сян «Хайнань нь цаг уур, байгалийн нөөцөөр Гавайн аралтай адил юм. Гавайн арал нь хөдөө аж ахуй, түүний бүтээгдэхүүнийг боловсруулах, жуулчлал зэрэгт тулгуурлан хөгжсөн билээ. Иймд бид Гавайн арлын туршлагаас суралцаж Хайнанийг хөгжүүлж болох юм»<sup>4</sup> гэж үзсэн болно. Мужийн дарга Лян Сяний хэлснээр бол гадаадын хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэхдээ Гонконгийн эдийн засгийн механизмыг үлгэр болгон авах ажээ.<sup>5</sup> Хайнань мужийн засаг захиргаа дараахь хэд хэдэн зүйлд гол анхаарлаа чиглүүлж байна.

**1. Гадаадын хөрөнгө оруулалт.** Хайнань арлыг ЭЗОБ болгох бэлтгэл ажил хийж байх үед буюу 1988 оны 3-р сарын 5-ны өдөр Төрийн Зөвлөлийн гишүүн Гу Му БХАТИХ-ын Байнгын Хорооны хуралд «Хайнань арлыг манай улсын хамгийн том ЭЗОБ болгох, гадаадын хөрөнгө оруулагчдад бусад ЭЗОБ-д мөрдөж байгаагаас илүү хандах, эдийн засаг, удирдлагын системийг мөн уян хатан болгохоор Төрийн Зөвлөл санал оруулж байгаа нь гадаадын худалдаачдын анхаарлыг татах хөрөнгө оруулалтын аятай нөхцөл бүрдүүлэх, бүтээн байгуулалтын хөгжлийг хурдасгах зорилготой юм»<sup>6</sup> гэж хэлсэн билээ. Үүний дараахан БНХАУ-ын Төрийн Зөвлөл «Хайнань аралд хөрөнгө оруулахыг урамшуулах тогтоол»-ыг 1988 оны 5-р сарын 4-нд батлан гаргасан.<sup>7</sup> Энэхүү тогтоолоос харахад Хайнаний ЭЗОБ-ийг хөгжүүлэхэд бусад ЭЗОБ-ээс илүү уян хатан хандаж байгаа нь тодорхой байна. Тогтоолд үйлдвэр, байгууламжийн онцлог байдлаас шалтгаалан хөрөнгө оруулагчдын улсын газрыг ашиглах хугацаа харилцан адилгүй байж болох боловч цаад тал нь 70 жил байхаар заажээ. Хайнань аралд байгуулсан үйлдвэрийн газрын үйлдвэрлэл эрхлэн олсон ор-

лого буюу бусад орлогоос 15%-ийн ашгийн татвар, орон нутгийн 10% ийн татвар авах аж. Гэвч боомт, гарц, нисэх буудал, засмал зам төмөр зам, цахилгаан станц, уурхай, усан байгууламж зэрэг эдийн засгийн дэд бүтцийн барилга байгууламж, хөдөө аж ахуйн үйлдвэр эрхэлж буй үйлдвэрийн ажиллах хугацаа 15-аас дээш жил бол ашиг олсон эхний 5 жилд ашгийн татвараас чөлөөлж, 6—10 дахь жилд нь ашгийн татварыг 50 % -иар хөнгөлөх ажээ. Харин аж үйлдвэр, тээвэр, холбооны салбарын барилга байгууламж эрхэлж буй үйлдвэрийн ажиллах хугацаа 10-аас дээш жил бол ашиг олсон эхний 2 жилд ашгийн татвараас чөлөөлж, 3—5 дахь жилд нь 50%-ийн хөнгөлөлттэй татвар авах ба Хайнань мужийн ардын засгийн газар тэдгээр үйлдвэрийг тэргүүний техниктэй үйлдвэр гэж үзвэл 6-8 жилд нь 50% -ийн хөнгөлөлттэй татвар авах юм. Гэхдээ аж үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэр нь тогтоол ёсоор ашгийн татвараас чөлөөлөгдөх хугацаа дууссан ч тухайн жилийн экспортын бүтээгдэхүүний хэмжээ үйлдвэрийн тэр жилийн нийт бүтээгдэхүүний 70% -иас илүү гарвал тэр жилд нь 10% -ийн ашгийн татвар авах ажээ. Мөн түүнчлэн Хайнань аралд барьсан үйлдвэрийн газарт зайлшгүй шаардагдах машин, тоног төхөөрөмж, түүхий эд, сэлбэг хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, албан ажлын хэрэгцээний зүйлийг импортоор оруулахад гааль, бүтээгдэхүүн, нэмэгдэл татвараас чөлөөлнө. Харин эдгээр үйлдвэр нь аралд худалдаалахаар бараа оруулж ирвэл дээр дурдсан татварыг 50% -иар авах ажээ. Гадаадын хөрөнгө оруулагчид Хайнань аралд барьсан үйлдвэрээс олсон ашиг, валютыг гадаадад гаргахдаа валют гуйвуулах татвараас чөлөөлөгдөнө. Хэрвээ гадаадын хөрөнгө оруулагчид Хайнань аралд барьсан үйлдвэрээс олсон ашгаасаа хятадын нутагт 5-аас доошгүй жилээр дахин хөрөнгө оруулбал нэгэнт төлсөн ашгийн татварын 40% -ийг эргүүлж олгоно. Харин дэд бүтцийн барилга байгууламж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, бүтээгдэхүүн экспортлох үйлдвэр, тэргүүний техниктэй үйлдвэрт хөрөнгө оруулбал хураасан ашгийн татварыг бүгдийг нь буцааж өгөх ажээ. Мөн Тайвань, Гонконг, Макаогийн эх орон нэгтнүүд тус мужид орж гарахад илүү хялбар дөхөм болох юм байна.

Ер нь нээлттэй бодлогын хэрэгжилтэд гадаад олон оронд суугаа хятадын цагаач иргэд чухал үүрэг гүйцэтгэдэг юм. Хайнаниас гарч олон орон, бүс нутагт суугаа 1,7 сая цагаач иргэн тус мужийн цаашдын хөгжилд зохих нөлөө үзүүлэх нь дамжиггүй. Дашрамд өгүүлэхэд Хайнань муж Тайваньтай харилцах харилцаанд их ач холбогдол өгч байна. Лян Сян мужийн дарга болуут Тайваний эх орон нэгтнүүд Хайнаньд хөрөнгө оруулахыг урамшуулж Тайваний хөрөнгө оруулалтын хэд хэдэн бүс байгуулах болно гэж мэдэгдсэн<sup>8</sup>. Түүний хэлснээр энэ бүсийг зохимжтой газар байгуулж, илүү аятай таатай нөхцөл бүрдүүлэх ажээ.

**2. Эдийн засгийн дэд бүтэц.** Хайнань мужийн эдийн засгийн дэд бүтэц үнэхээр хоцрогдсон гэж хэлж болно. Иймд БНХАУ-ын Төрийн Зөвлөл ч, Хайнань мужийн ардын засгийн газар ч хөрөнгө оруулалтын дийлэнхийг дэд бүтцийг хөгжүүлэхэд зориулах бодлоготой байгаа нь урьд дурдсан тогтоолд өгүүлснээс тодорхой байгаа юм. Эдийн засгийн дэд бүтцийн барилга байгууламжид хөрөнгө оруулагчдад илүү их хөнгөлөлт олгохоор дээрх тогтоолд заасан байсан. 1988 оны байдлаар тус мужид 380 мянган.кв эрчим хүч гаргах цахилгаан станц, 25 мянган кв эрчим хүч гаргах усан цахилгаан станц байгаа бөгөөд тэдгээрийн хүчин чадлыг 1995 онд тус бүр 1,5 болон 2 сая кв эрчим хүчид хүргэхээр төлөвлөж байна<sup>9</sup>. Гонконг-Макаогийн олон улсын хөрөнгө

оруулалтын компани дулааны цахилгаан станц барихад 82 сая долларын хөрөнгө оруулснаас гадна Японы нэгэн пүүсний хөрөнгө оруулсан 1 сая кВ. эрчим хүч гаргах ДЦС-ыг барих ажил эхлээд байна. Гонконг руу өдөр бүр нислэг хийх бололцоотой Фэнхуаны олон улсын нисэх буудлыг Саняа хотод барьж энэ онд ашиглалтад оруулах юм. Хайнань нь 1000 км урт, 12 метрийн өргөн асфальтан замтай бөгөөд Хайкоу Саняагийн замыг шинэчлэн засч байна. Тус муж харилцаа холбоог хөгжүүлэхэд их анхаарч байгаагийн үр дүнд эх газар болон Гонконг, Макаотай харилцах нөхцөл сайжирчээ. Үүнээс гадна Хайкоу, Саняа, Янпу зэрэг газарт хиймэл дагуулын мэдээг хүлээн авах станц барьж эхлээд байна.<sup>10</sup> Тус мужийн дарга Лян Сян «Эхний гурван жилдээ эрчим хүч, тээвэр, холбоо, усан хангамжийг хөгжүүлэх суурь тавих болно»<sup>11</sup> гэж мэдэгдэж байсны дагуу энэ ажилд илүү их анхаарал тавьж байна.

**3. Жуулчлал.** Байгаль, цаг уурын нөхцөлийн хувьд энэ мужид жуулчлалыг хөгжүүлэх их бололцоотой. Энд жуулчин хүлээж авч болох 123 газар байгаагаас 40 гаруй нь бусдаасаа илүү гэж үздэг байна. Валют олох хамгийн найдвартай арга бол энд олон улсын жуулчлалыг хөгжүүлэх явдал гэж мэргэжилтнүүд тооцоолж байгаа юм. Далайн эргийн элсэн хөвөө, амттай сайхан хоол ундаа, цаг агаарын тааламжтай нөхцөл энэ бүхэн далайн амрагч, жуулчдын сонирхлыг татах нь дамжиггүй. Гадаадын жуулчны компаниуд Хайнанийг их сонирхож байна. Одоогийн байдлаар Гонконгийн нэг худалдаачин 30 хав. дөр.км талбайтай олон улсын жуулчны төв барихад 6,74 сая долларын хөрөнгө оруулаад байна.

**4. Аж үйлдвэр.** Тус муж аж үйлдвэрийн газар барьж байгуулахад багагүй анхаарал тавьж байна. 1988 оны эцсийн байдлаар дотоодын хөрөнгө оруулалтаар үйлдвэр 2710, үүний дотор хамтарсан үйлдвэр 915, дагнасан үйлдвэр 1795-ыг барихыг зөвшөөрчээ.<sup>12</sup> Үүнээс гадна гадаадтай хамтарсан, хоршсон, дагнасан 446 үйлдвэр барихыг зөвшөөрсөн байна.

Аж үйлдвэрийг хөгжүүлэхдээ дараахь хэдэн чиглэлд анхаарлаа төвлөрүүлж байна.

-- Халуун бүсийн хөдөө аж ахуйн ургамлыг үйлдвэрлэх, тухайл бал дал модны цуулт, каучук, наргил, чихрийн нишингэ, цай боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх;

— Модон бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүн боловсруулахын тул ойн аж ахуй, мал аж ахуй, загасны аж ахуйг хөгжүүлж, далайн янз бүрийн ургамлыг тариалах;

- Нүүрсний үйлдвэрийг бүх талаар хөгжүүлэх үндсэн дээр төмөрлөг, цемент, шилний үйлдвэрийн баазтай болох;

— Нефтехимийн үйлдвэрийг хөгжүүлэх.

Хайнаний аж үйлдвэрийн хөгжилд «Янпугийн аж үйлдвэрийн хөгжлийн бүс» тодорхой үүрэг гүйцэтгэх болно. Янпугийн хөгжлийн бүс нь 30 хав.дөр.км талбайтай агаад хятадын ийм төрлийн бүс дотроо хамгийн томд орно. Энэ бүсийг чөлөөт боомтын хэлбэрээр зохион байгуулж байна. Энд нефть, байгалийн хий зэрэг химийн 8 том барилга байгууламж барихаар урьдчилан 13 гаруй тэрбум юаний хөрөнгө оруулах юм.<sup>13</sup>

Хайнанийг бие даасан муж, эдийн засгийн онцгой бүс болгож, бүтээн байгуулалтын их ажил өрнөж буй өдгөө үед хөрөнгө мөнгө, мэргэжилтэй боловсон хүчин дутагдах, эдийн засгийн дэд бүтцийн хөгжил сул дорой байгаа зэрэг үндсэн хэд хэдэн бэрхшээл тулгарч бай-

на. Гэвч далайн эргийн бусад бүс нутагтай харьцуулахад эдүгээ нэлээд хоцрогдонгуй байгаа эдийн засгийн бэрхшээлийг давж туулна гэдэг амаргүй билээ. Гагцхүү нээлттэй бодлогын уян хатан механизмыг мужийн давуу талтай зөв хослуулж чадсан цагт сая амжилт олж чадна.

<sup>1</sup> "Far eastern economic review" 1989 No 20

<sup>2</sup> Дэн Сяопин, «Основные вопросы современного Китая» М., 1988. с. 56-57

<sup>3</sup> «Жэньминь жибао» 1988. IV.14

<sup>4</sup> "Beijing review" 1988 No 18

<sup>5</sup> «Новое время, 1989. No 20

<sup>6</sup> «Жэньминь жибао» 1988. Ш. 6

<sup>7</sup> «Жэньминь жибао» 1988. V.5

<sup>8</sup> «Жэньминь жибао» 1988.V Ш.26

<sup>9</sup> "China reconstructs" 1988 No 12 –

<sup>10</sup> «Жэньминь жибао» 1989.1.1

<sup>11</sup> "China reconstructs" 1988 No 12

<sup>12</sup> «Жэньминь жибао» 1989 1.16

<sup>13</sup> «Вэньхуй бао» 1989. 1.12

**СОЦИАЛИСТ ЧИГ  
БАРИМЖААТ ОРНУУДЫН  
НИЙГЭМ-ЭДИЙН  
ЗАСГИЙН ХӨГЖЛИЙГ  
ТҮРГЭТГЭХЭД ҮНДЭСНИЙ  
БОЛОВСОН ХҮЧНИЙ  
ҮҮРЭГ**

**3. Эрдэнэчимэг**

Нийгмийн нөхөн үйлдвэрлэлийн нэн чухал бүрэлдэхүүн хэсэг нь нийгмийн ажиллах хүчний нөхөн үйлдвэрлэл байдаг бөгөөд тэр нь ажиллах хүчний тоо ба чанарын өөрчлөлтөөр тодорхойлогдоно. Шинжлэх ухаан, техникийн дэвшлийн өнөө үед тусгаар тогтнолоо тунхаглан, улс орноо социалист чиг баримжаагаар хөгжүүлж буй оронд ажиллах хүчний нөхөн үйлдвэрлэлийн чанарын өөрчлөлтийг чухалчилж байна. Социалист чиг баримжаат орнууд үндэсний мэргэжилтэй ажиллах хүчин бэлтгэх асуудлыг хүнд үйлдвэржилт, хөдөө аж ахуйн хоршоолол, улсын сектортой эн зэрэгцүүлэн тавьж байна.

Ер нь мэргэжилтэй ажиллах хүчний өсөлтийг дагаж нийгмийн материаллаг баялаг нэмэгдэхийн хамт хөдөлмөрчдийн оюуны баялаг ч улам бүр өсөн өргөжиж байдаг зүй тогтолтой.

Аливаа нийгмийн үйлдвэрлэлийн өсөлтөд тухайн нийгмийн хөдөлмөрийн нөөц, түүний өсөлт, бүтэц шууд нөлөөтэй байдаг. Ийм учраас мэргэжилтэй ажиллах хүч нь нийгмийн үйлдвэрлэлд тодорхой байр суурь эзлэн, онцгой үүрэг гүйцэтгэгч хүч болдог. Хүн амын тоо, ялангуяа хөдөлмөрийн чадвартай хүмүүс, тэдгээрийн мэргэжил, боловсролын бүтэц, түвшин нь нийгмийн баялагийг бүтээн үйлдвэрлэх,